



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/126

Номгон


Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжсэн
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "б", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 176 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/342, А/381, А/401 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгаж байгаатай холбогдуулан коронавируст халдвар тархах эрсдэлээс иргэд, олон нийтийнхээ эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймгийн хэмжээнд 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 00:00 цагаас 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 24:00 цаг хүртэл гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгаж, халдвар хамгааллын арга хэмжээг олон нийтэд мөрдүүлсүгэй.

2. Халдварын тархалтын "Улбар шар" түвшинд шилжсэн хугацаанд холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж), Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  МӨНХСАЙХАН

621011077